

"ДБЭХС" ТӨХК-ИЙН ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ХОРООНЫ

2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙСЭН ТАЙЛАН

2022.03.22

Хэрлэн сум

Хянан шалгах комисс нь үйлдвэрчний эвлэлийн 2022 оны үйл ажиллагаанд доорх агуулгын хүрээнд хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ. Шалгалтын бүрэлдэхүүнд комиссын дарга Н.Азжаргал, гишүүд С.Баатарцогт, Т.Батбаяр нар ажиллалаа.

1. Хяналт шалгалтын зорилго
2. Хамрах хүрээ
 - Төсөв төлөвлөлт
 - Мөнгөн хөрөнгө
 - Цалин, урамшуулал
 - Үндсэн хөрөнгө
 - Өргөдөл гомдол шийдвэрлэсэн байдал
 - Хамтын гэрээний биелэлт
 - Тогтоол шийдвэр, албан хэрэг хөтлөлт
3. Өмнөх шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгаж, зөвлөмжийн хэрэгжилтийг хангасан байдал
4. Баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал
5. Шалгалтын мөрөөр авах арга хэмжээ, зөвлөмж

НЭГ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО

Үйлдвэрчний эвлэлийн хорооны үйл ажиллагаа, санхүүгийн баримтад шалгалт хийснээр татвар төлөгч гишүүдийн татварын зарцуулалт дүрэм журмын хүрээнд зөв зохистой хийгдэж байгаа эсэх, мөн баримт бичгийн бүрдэл, төсөв төлөвлөгөө, хамтын гэрээ болон тогтоол шийдвэрийн биелэлтэд хяналт тавих, зөрчил дутагдлыг арилгуулах, зөвлөмж өгөх зорилготой.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

2.1. ТӨСӨВ ТӨЛӨВЛӨЛТ БОЛОН ГҮЙЦЭТГЭЛ

Үйлдвэрчний эвлэлийн хороо нь тухайн онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган түүнтэй уялдуулан Монголын эрчим хүч, геологи, уул уурхайн ҮЭ-ийн холбооны гишүүн ҮЭ-ийн хороод мөнгөн хөрөнгө зарцуулах журмыг мөрдөж санхүүгийн зарцуулалтын хувьд дараах зарчмыг баримтлан ажиллана.

2022 онд 105,962.76 мянган төгрөгийн орлого олж 113,817.69 мянган төгрөгийн зардал гаргахаар төлөвлөснөөс 114,098.49 мянган төгрөгийн орлого олж, 107,268.66 мянган төгрөгийн зардал гаргаж ажилласан байна.

2.2. МӨНГӨН ХӨРӨНГӨ

2022 оны 12-р сарын 31-ний өдрөөр мөнгөн хөрөнгө дараах үлдэгдэлтэй байна.

Д/д	Үзүүлэлт	Данс	Эхний үлдэгдэл /2022.01.01/ төг	Эцсийн үлдэгдэл /2022.12.31/ төг
1	Хас банкин дахь харилцах	5001129233	8,671,098.83	16,031,928.87
2	Касс		590,385.64	231.44
3	Эв нэгдлийн хамтын сан	5003394151	7,665,666.64	9,768,235.14
	Нийт дүн		16,927,151.11	25,800,395.45

Харилцахын үлдэгдэл нь банкнаас гаргасан дансны үлдэгдлийн баталгаагаар баталгаажсан. 2022 онд харилцах дансаар 111,284,467.59 төгрөгийн орлого, 103,923,637.55 төгрөгийн зардлын гүйлгээ хийгдсэн байна. Мөн кассаар 18,288,000.00 төгрөгийн орлого, 18,878,154.00 төгрөгийн зардлын гүйлгээ хийгдсэн байна.

2.3. ЦАЛИН УРАМШУУЛАЛ, ГИШҮҮНЧЛЭЛИЙН ТАТВАР

Тус үйлдвэрчний хороо нь 2022 онд орон тооны дарга-1, орон тооны бус нягтлан бодогч-1, саам сувиллын сахиул-1, гэрээт ажилтан -1, 12 тэргүүлэгч, ХШК-ийн 3 гишүүнд цалин урамшуулал олгосон. Цалин, урамшууллын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулбал:

д/д	Үзүүлэлт	Төлөвлөгөө /мян.төг/	Гүйцэтгэл /мян.төг/
1	Даргын цалин	17,832.21	18,470.12
2	Нягтлан бодогчийн цалин	4,390.65	4,390.65
3	Тэргүүлэгч, ХШК-ийн урамшуулал	3,600.00	3,600.00
4	Саамны сахиулын цалин	3,840.00	5,695.11
5	Ногоочны цалин	3,500.00	3,103.33
6	Татвар, НДШ	8,224.83	12,886.84
7	МЭХГУУ-ҮЭХ-ны татвар	9,000.00	0.00
8	Аймгийн ҮЭХ-ны татвар	6,000.00	6,000.00
	Нийт дүн	56,387.69	54,146.05

Тайлбар:

МЭХГУУ-н ҮЭХ-ны 2022 оны гишүүнчлэлийн татвар болох 9 сая төгрөг төсөвлөснөөс тухайн онд гишүүнчлэлийн татвар төлөөгүй. 2022 оны гишүүнчлэлийн татварын 50% болох 4,5 сая төгрөгийг 2023 оны 2-р сард ДУЛААН ЦАХИЛГААН ҮЙЛДВЭРЛЭГЧ ТҮГЭЭГЧДИЙН ҮЭ-ийн холбооны дансанд шилжүүлсэн.

Нийгмийн даатгалын шимтгэл, цалин хөлс болон суутган тооцсон татварын тооцоог холбогдох газруудад тухай бүр шилжүүлж тооцоо нийлж ажилласан байна. Цалин болон татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал нь нийт зардлын 52.1 хувийг эзэлж байна.

2.4. ҮНДСЭН ХӨРӨНГӨ

д/д	Хөрөнгийн нэр	Тоо ширхэг	Өртөг
1	Барилга, байгууламж	6	43,559,676.48
2	Тавилга, эд хогшил	32	8,600,200.00
3	Компьютер, техник хэрэгсэл	1	487,000.00
	Нийт дүн	39	52,646,876.48

Үндсэн хөрөнгө, тоног төхөөрөмжийн хуримтлагдсан элэгдлийн дүн 16,971,678.00 төгрөг байна.

2.5. ӨРГӨДӨЛ ГОМДОЛ, ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ

Нийт 17 өргөдөл, санал хүсэлт ирснийг тухай бүрт нь өөрийн эрхийн хүрээнд болон холбогдох газруудтай хамтран шийдвэрлэсэн, Мөн дээд шатны байгууллагад шийдвэрлүүлэхээр албан бичгээр хандсан байна. Ирсэн өргөдлийг төрлөөр нь ангилбал:

- Хамгаалах хэрэгслийн нийлүүлэлт, чанарын талаар - 1
- Цалин нэмэгдүүлэх тухай – 3
- Хөдөлмөрийн хуулийн 89-р зүйлийн 89.1, 89.2, 89.3-р зүйлийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай санал-1
- Буцалтгүй тусламж хүссэн өргөдөл-1

- Цайны газрын хоолны амт чанар, харилцааг сайжруулах – 4
- Цайны газрын хариу тайлбар-1
- 2023 оны хамтын гэрээнд оруулах санал-7

2.6. ХАМТЫН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Үйлдвэрчний эвлэлийн хороо нь компанийн захиргаатай тухайн онд хэрэгжих хамтын гэрээг байгуулан ажилласан байна. 2022 онд хэрэгжих хамтын гэрээ нь 2022 оны 02 дүгээр сарын 11-ны өдөр батлагдаж хэрэгжсэн. 2022 онд хамтын гэрээний хэрэгжилтээр дараах гүйцэтгэл гарсан байна. Үүнд:

д/д	Үзүүлэлт	Зарцуулагдсан хөрөнгийн хэмжээ
1	Нийт татвар төлөгчийн тоо	619
2	Цалингийн сангийн гүйцэтгэл /сая.төг/	15,901.4
3	Дундаж цалин /мян.төг/	2,140.74
4	Нэмэгдэл хөлс /сая.төг/	6,725.3
5	Шагнал урамшуулал, жилийн үр дүн /сая.төг/	1,263.9
6	Хөнгөлөлт /сая.төг/	537.25
7	Тэтгэмж /сая.төг/	284.80
8	Тусламж /сая.төг/	58.60
9	Хөдөлмөр хамгааллын зардалд зарцуулсан хөрөнгө /сая.төг/	483.40
	Нийт дүн	25,256.79

2.7. ТОГТООЛ ШИЙДВЭР, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТ

2022 онд Бүх гишүүдийн хурлын тогтоол 1 ширхэг, хурлын тэмдэглэл 1 ширхэг, Сонгууль зохион байгуулах комиссын шийдвэр-2 ширхэг, Тэргүүлэгчдийн хурлын тогтоол 15 ширхэг, хурлын тэмдэглэл 8 ширхэг үйлдсэн байна. /2022 оны 1-р сарын 10-ний өдрийн №02 тоот тогтоолын дугаар 2022 оны 2-р сарын 11-ний өдрийн тогтоолын дугаартай давхардсан/. 15 ширхэг албан бичиг ирсэн, 37 ширхэг албан бичиг явуулсан.

2.8. ОЛОЛТ АМЖИЛТ

- Хөдөлмөрийн тухай хуулийн /Шинэчилсэн найруулга/-ын 109-р зүйлийн 109.3-р зүйлийн хэрэгжилтийг хангуулж шөнийн цагийн нэмэгдлийг 1,2 дахин тооцуулж олгохоор шийдвэрлүүлж ажилласан байна.
- ХАБЭА-н сэдэвт ажил мэрэгэжлийн уралдаант сургалтыг анх удаа амжилттай зохион байгуулж ажилласан байна.
- Гишүүдийн саналыг удаа дараа дээд шатны байгууллагад дамжуулж албан бичгээр хандаж ажилласан байна.

ГУРАВ. ӨМНӨХ ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ ДУТАГДЛЫГ АРИЛГАСАН БАЙДАЛ

1. 2021 оны тайланд хийсэн шалгалтаар баримтын нийт 7,944,300.00 төгрөгийн зөрчил илрүүлж шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгаж 2022.04.20-ны дотор ХШК-т бичгээр тайлбар ирүүлэхийг мэдэгдсэн байна.Дээрх зөрчлөөс нийт 301,500.00 төгрөгийн зөрчлийг арилгаж 7,642,800.00 төгрөгийн зөрчлийг арилгаагүй тул нөхөн төлүүлэхээр шийдвэрлэв.
2. Тогтоол шийдвэрийн бичвэрийг үг, үсгийн алдаатай боловсруулсан. Албан хэрэг хөтлөлтийн стандарт мөрдөгдөөгүй. Албан бичгийн зөв бичих дүрэм болон стандарт мөрдөгдөөгүй хэвээр байна.
3. Анхан шатны баримтын зөрчил арилгаж тайлбар ирүүлсэн байдал:

д/д	Баримтын огноо	Зөрчил	Зөрчил арилгасан байдал
1	2021.06.02	МЭХГУУҮЭХ-с ирүүлсэн албан бичгийн дагуу олон улсын сургалтанд /Улаанбаатар хотод/ хамрагдахдаа хоол болон зочид буудлын төлбөрийг салбарын холбооноос хариуцах тухай заасан атал 3 хоногийн хоол, буудлын төлбөр 414,000 төгрөгийг томилолтоор авч UB GRAND hotel гэх баримтаар хаасан.	
2	2021.07.11 2021.08.12	Төлбөрийн даалгаварт мөнгөн дүнг тоогоор 907,000 үсгээр Долоон зуун мянган төгрөг гэсэн зөрүүтэй дүнгээр гүйлгээ хийсэн.	Төлбөрийн даалгаварыг засаж, тамга тэмдгээр баталгаажуулах хавсаргасан.
3	2021.09.07	МЭХГУУҮЭХ-с ирүүлсэн албан бичгийн дагуу олон улсын сургалтанд /Улаанбаатар хотод/ хамрагдахдаа хоол болон зочид буудлын төлбөрийг салбарын холбооноос хариуцах тухай заасан атал 4 хоногийн хоол, буудлын төлбөр 276,000 төгрөгийг томилолтоор авч UB GRAND hotel гэх тамга дарсан, гарын үсэггүй баримтаар хаасан.	
4	2021.10.04	Нэхэмжлэх болон төлбөрийн баримтаар 34,500 төгрөг байхад төлбөрийн даалгавраар 36,000 төгрөгийн гүйлгээ хийсэн. 1500 төгрөг баримтаар нотлогдоогүй.	Нэхэмжлэхийг төлбөрийн даалгаврын дүнгээр бичүүлэн тамга тэмдгээр баталгаажуулсан.
5	2021.11.19	Бэлтгэн нийлүүлэгч тодорхойгүй, тамга тэмдэггүй биллээр 206,250 төгрөгийн баримт бүрдүүлсэн.	Бэлтгэн нийлүүлэгчээс тамга тэмдэгтэй баримт авч хавсаргасан.
6	2021.11.08	МЭХГУУҮЭХ-с ирүүлсэн албан бичгийн дагуу олон улсын сургалтанд /Хаан жимс амралтанд/ хамрагдахдаа хоол болон зочид буудлын төлбөрийг салбарын холбооноос хариуцах тухай заасан атал 3 хоногийн хоол, буудлын төлбөр 414,000 төгрөгийг томилолтоор авч Дархан-Уул аймгийн "Дархан цагаан алт" ХХК гэх баримтаар хаасан.	
7	2021.11.17	МЭХГУУҮЭХ-с ирүүлсэн албан бичгийн дагуу Гүйцэтгэх хорооны хуралд хамрагдахдаа хоол болон зочид буудлын төлбөрийг салбарын холбооноос хариуцах тухай заасан атал 3 хоногийн хоол, буудлын төлбөр 207,000 төгрөгийг томилолтоор "Рич холдинг" ХХК гэх 210,000 төгрөгийн гарын үсэггүй баримтаар хаасан. Цагийн балансад 2 хоногийн томилолт оруулсан.	
8	2021.11.29	Залуучуудын холбооны дарга Х.Добумэргэнбаатар гэсэн хувь хүний дансанд 300,000 төгрөг шилжүүлсэн. 10 медалийн үнэ шилжүүлсэн боловч 5 хүн шагнуулсан зураг хавсаргасан. Бусад шагнал авсан хүмүүсийн нэрсийн жагсаалт болон, шагналд тодорхойлсон үндэслэл тодорхойгүй.	Залуучуудын холбоон дээр 5 хүний шагнал байгаа бөгөөд одоогоор тодорхойлсон хүн байхгүй байгаа.
9	2021.12.14	МҮЭХ-ны 23-р их хуралд оролцохдоо буудлын төлбөр 265,000 төгрөгийг "Рич	

		холдинг" ХХК гэх 350,000 төгрөгийн гарын үсэггүй баримтаар хаасан.	
10		Ажиллагсдын дархлаажуулалтанд зориулж 6,066,800 төгрөгийг зарцуулахдаа баримт бичгийн бүрэн бүтэн байдлыг хангаагүй, ҮЭХ-н дарга гарын үсэг тамга тэмдгээр баталгаажуулаагүй хүчин төгөлдөр бус тогтоолыг үндэслэн төсөвт тусгаагүй зардал гаргасан.	Тэргүүлэгчдийн тогтоол үл ойлголцлоос болж бүрэн бүтэн байдал алдагдсан бөгөөд дарга гарын үсэг зурж

ДӨРӨВ.БАРИМТЫН ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ ДУТАГДАЛ

Худалдан авалтын Е баримтыг анхан шатны баримтад хавсаргаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.3 дахь заалтад "анхан шатны баримт гэж, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог", 13.4 дэх хэсэгт "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.", 13.5 дахь хэсэгт "... цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 6.5 дахь Монгол Улсын стандарт MNS 6529:2015 "татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан тусгай нууцлалын QR кодоор баталгаажсан анхан шатны цаасан баримтуудыг бүрдүүлж ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч Е баримтыг хавсаргах" гэснийг зөрчсөн байна.

Үүнд:

д/д	Баримтын огноо	Гүйлгээний утга	Зөрчил
1	2022.01.07	Хөдөлмөрийн хуулийн эмхэтгэл номны үнэ олгов.	Хүлээн авагч: Самдан овогтой Хүрэлсодномын дансанд 2,850,000.00 төгрөг шилжүүлсэн. 2022 оны төлөвлөгөө батлах тухай 1-р сарын 05-ний өдрийн 01 тоот тогтоолыг 1-р сарын 10нд дахин хуралдаж нөхөж гарын үсэг зурж баталсан нь хурлын тэмдэглэлээр нотлогдож байна.Мөн ҮЭХ-ний тэргүүлэгчдийн хурлын /2022 оны 02-р сарын 11-ний өдрийн Тайлант сонгуулийн хурлын зардал тогтоох тухай 04 тоот тогтоолоор 12 сая төгрөгийг зарцуулах тухай тэргүүлэгчид дахин баталсан/. Номны анхан шатны баримт QR кодоор баталгаажгаагүй. Суутган тооцоогүй татварын мэдээгээр баталгаажсан.
2	2022.01.28	1-р сарын цалин олгов. /Д.Гүнсмаа/	2022 оны 2-р сарын 11-ний өдрийн 05 тоот тогтоолоор ҮЭХ-ний даргын цалинг 100,000.00 төгрөгөөр нэмэгдүүлж үндсэн цалинг 1,914,000.00 төгрөг болгож баталгаажуулсан. 1-р сарын урьдчилгаа 907,000.00 төгрөг, сарын сүүлийн цалин 617,501.00 төгрөг олгож Тэргүүлэгчдийн тогтоол гараагүй байхад 1-р сарын цалинг нэмэгдүүлэн тооцож олгосон.
3	2022.02.14	14ш поло подволканы үнэ шилжүүлэв. 140,000.00 төгрөг	Хүлээн авагч: Оргодол овогтой Баярмаа-ийн дансанд шилжүүлсэн. Нэхэмжлэх байхгүй, бэлэн мөнгө хүссэн өргөдөл бичсэн, зарлагын падаанд Богд өөд ХХК гэсэн тамгатай. Анхан шатны баримт QR кодоор баталгаажгаагүй.
4	2022.02.22	Видео тайлангийн урьдчилгаа шилжүүлэв.	Сайн аялал ХХК-ийн дансанд 1,000,000.00 төгрөг шилжүүлсэн. Анхан шатны баримт QR кодоор баталгаажгаагүй.
5	2022.03.01	Видео тайлангийн үлдэгдэл шилжүүлэв.	Сайн аялал ХХК-ийн дансанд 1,000,000.00 төгрөг шилжүүлсэн. Анхан шатны баримт QR кодоор баталгаажгаагүй.

6	2022.03.09	Дараа тооцоогоор томилолтын зардал олгов. /Д.Гүнсмаа/	3-р сарын 10-аас 11-нд 1 хүн 3 өдрийн томилолт 302,200.00 төгрөг авсан. 2 өдөр ажилласан 1 өдрийн мөнгө буцааж тушаагаагүй. Буудлын төлбөрийн анхан шатны баримт QR кодоор баталгаажуагүй. Ирсэн бичиг болон удирдамж байхгүй. МЭХГУУ-н салбарын ҮЭ-ийн холбооны нөхцөл байдал ээлжит бус бага хуралтай холбогдуулан Эрчим хүчний үйлдвэр компаниудын ҮЭ-ийн хороодын дарга нар МҮЭ-ийн холбооны ерөнхийлөгчтэй өмнөх даргын эрх мэдлээ хэтрүүлэн ашигласан талаар уулзсан.
7	2022.03.15	Дараа тооцоогоор томилолтын зардал олгов. /Д.Гүнсмаа/	3-р сарын 16-аас 18нд 3 хүн 3 өдрийн томилолт 906,600.00 төгрөг авсан. МЭХГУУ-н салбарын ҮЭ-ийн холбооны нөхцөл байдал ээлжит бус бага хурал. Хамт явах ажилтны томилолтыг өөрийн хувийн дансанд авсан. Буудлын төлбөрийн анхан шатны баримт QR кодоор баталгаажуагүй..
8	2022.04.21	Дараа тооцоогоор томилолтын зардал олгов. /Д.Гүнсмаа/	4-р сарын 22-24нд томилолт 1 хүн 2 өдрийн томилолт 233,200.00 төгрөг авсан. ЭХ-ний үйлдвэр компаниудын ҮЭ-ийн холбооны дарга нар ДЦС-2 дээр уулзалт зөвлөгөөн хийсэн.Ирсэн бичиг болон удирдамж байхгүй.Буудлын төлбөр дүн засвартай, анхан шатны баримт QR кодоор баталгаажуагүй. 1 өдрийн томилолтыг компанийн цагийн баланснаас хасаагүй.
9	2022.05.24	Голланд огурцы үнэ олгов.	Хүлээн авагч: Ч.Отгончулуун 225,000.00 төгрөг. Нэхэмжлэх байхгүй бэлэн мөнгө олгохыг хүссэн өргөдөл бичүүлж тухайн иргэний дансанд шилжүүлсэн. Анхан шатны баримт QR кодоор баталгаажуагүй.
10	2022.05.27	Ногооны талбайг хагалж шиирүүлэх ажлын хөлс.	Хүлээн авагч: Г.Болдбаатар 400,000.00 төгрөг. Хөлсөөр ажилах гэрээ байхгүй, хүсэлт бичүүлж тухайн иргэний дансанд шилжүүлсэн. Ажлын хөлснөөс ХХОАТ, НДШ суутгаагүй.
11	2022.05.30	Үр, үрсэлгээний үнэ олгов.	Хүлээн авагч: С.Энхтулга 75,000.00 төгрөг.Нэхэмжлэх байхгүй хүсэлт бичүүлж тухайн иргэний дансанд шилжүүлсэн. Анхан шатны баримт QR кодоор баталгаажуагүй.
12	2022.05.30	Ногоочны ажлын хөлс.	Хүлээн авагч: Ж.Баттулга 1003,333.00 төгрөг.Хөлсөөр ажиллах гэрээг 4-р сарын 18-аас 9-р сарын 15-ны хооронд нэг сарын ажиллах хөлс 700,000.00 төгрөг байна гэж хийсэн. Ажлын хөлснөөс ХХОАТ, НДШ суутгаагүй тухайн иргэний дансанд шилжүүлсэн.
13	2022.06.20	Дараа тооцоогоор томилолтын зардал олгов. /Д.Гүнсмаа	6-р сарын 21-нээс 1 хүн 3 өдрийн томилолт 527,800.00 төгрөг авсан. МҮЭ-ийн холбооны залуу сонгуульт ажилтнуудын чуулга уулзалтанд оролцсон. Ирсэн бичиг болон удирдамж байхгүй. Буудлын төлбөрийн анхан шатны баримт QR кодоор баталгаажуагүй.
14	2022.05.30	Үр төмс, ногооны үр	Хүлээн авагч: Ж.Рэнцэнзаяа 73,900.00 төгрөг.Нэхэмжлэх байхгүй бэлэн мөнгө хүссэн өргөдөл бичүүлж тухайн иргэний дансанд шилжүүлсэн. Анхан шатны баримт QR кодоор баталгаажуагүй.
15	2022.08.16	Дараа тооцоогоор томилолтын зардал олгов. /Д.Гүнсмаа/	8-р сарын 19-өөс 2 хүн 3 өдрийн томилолт 1042,400.00 төгрөг авсан. МҮЭ-ийн холбооны 105 жилийн ойд бөхийн хамт оролцов. Ирсэн бичиг, удирдамж байхгүй. Хамт явах ажилтны томилолтыг өөрийн хувийн дансанд авсан. Буудлын төлбөрийн анхан шатны баримт огноогүй, QR кодоор баталгаажуагүй.
16	2022.08.30	Дараа тооцоогоор томилолтын зардал олгов. /Д.Гүнсмаа/	8-р сарын 30-ний өдрөөс 1 хүн 2 өдрийн 379,200.00 төгрөг авсан. МҮЭ-нийн холбооны 2022 оны 08-р сарын 29-ний өдрийн 05/338 тоот албан бичигт МҮЭ-ийн холбооны эрхийн хороонд гаргасан гомдлын дагуу 08-р сарын 31-ний өдрийн 15 цагт хуралдана.Буудлын

			төлбөрийн анхан шатны баримт QR кодоор баталгаажуулахгүй.
17	2022.10.17	Дараа тооцоогоор томилолтын зардал олгов. /Д.Гүнсмаа/	10-р сарын 17-ны өдрөөс 1 хүн 5 өдрийн 860,200.00 төгрөг авсан. 2022 оны 10-р сарын 10-ний өдрийн а/52 албан бичигт 2022 оны 10-р сарын 19-ний 17:00-19:00 цагт "Ажил хаялтын өмнөх анхааруулах тайван жагсаал, цуглаан"-ыг зохион байгуулах арга хэмжээнд хороодын дарга нар оролцохыг урьж байна. Томилолтын хуудас ирсэн буцсан огноо байхгүй. Буудлын анхан шатны баримт огноо байхгүй, QR кодоор баталгаажуулахгүй.
18	2022.10.31	ТАТВАР 10-Р САР	Хүлээн авагч: Дорнод аймгийн ҮЭ-ийн хороо 500,000.00 төгрөг. Төлбөрийн даалгаврын огноо, гүйлгээний утга засвартай.
19	2022.11.03	Дараа тооцоогоор томилолтын зардал олгов. /Д.Гүнсмаа/	11-р сарын 02-ний өдрөөс 1 хүн 3 өдрийн томилолт 527,800.00 төгрөг авсан.МЭХГУУ-н ҮЭХ-ны төлөөл ЭХЗХ-ний даргатай уулзах уулзалт 11-р сарын 03-ний өдрийн 14 цагт болов. Ирсэн бичиг байхгүй. Буудлын төлбөрийн анхан шатны баримт QR кодоор баталгаажуулахгүй.Томилолтын 3 хоног компанийн цагийн баланснаас хасагдаагүй.
20	2022.11.28	Дараа тооцоогоор томилолтын зардал олгов. /Д.Гүнсмаа/	11-р сарын 28-ний өдрөөс 1 хүн 3 өдрийн томилолт 527,800.00 төгрөг авсан. МҮЭ-ийн холбооны даргатай уулзсан.Ирсэн бичиг байхгүй Буудлын төлбөрийн анхан шатны баримт QR кодоор баталгаажуулахгүй. Томилолтын 3 хоног компанийн цагийн баланснаас хасагдаагүй.
21	2022.12.26	Дараа тооцоогоор томилолтын зардал олгов. /Д.Гүнсмаа/	12-р сарын 26-ний өдрөөс 1 хүн 4 өдрийн томилолт 669,800.00 төгрөг авса. 1.МҮЭ-ийн холбоо 2022 оны 12-р сарын 22-ний өдрийн 03/584 тоот албан бичиг 2022 оны үйл ажиллагааны товч тайлан "Нийгмийн шинэ гэрээ хэлэлцээр" арга хэмжээ. 2.2022 оны 12-р сарын 23-ний өдрийн №67 тоот албан бичиг МҮЭ-ийн холбооны гишүүн байгууллагуудын шилдгийн шилдэг тодруулах арга хэмжээ 27,28-ны өдрүүдэд УБ хотод зохион байгуулагдана. Буудлын төлбөрийн анхан шатны баримт QR кодоор баталгаажуулахгүй.. Дугааргүй тамгагүй баримт хавсаргасан.

ТАВ. ШАЛГАЛТЫН МӨРӨӨР АВАХ АРГА ХЭМЖЭЭ, ЗӨВЛӨМЖ

1. Төсөв боловсруулахдаа жилийн зорилт дэвшүүлж тухайн ажлыг гүйцэтгэх хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон тэргүүлэгчдийн хурлын тэмдэглэл, төсвийн нарийвчилсан судалгаа, дүрэм журмын үндэслэлийг тодорхой гарган хавсаргаж байх. Төсвийн төслийг ХШК-ийн гишүүдэд хянуулж батлах.
2. Төлбөр тооцоо, худалдан авалтыг нууцлалын QR кодоор баталгаажсан анхан шатны цаасан баримтуудыг бүрдүүлж ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч Е баримтыг хавсаргах шаардлагатай байна.
3. Гишүүдийн дундах тэмцээн уралдааныг ур чадвар, ажил мэргэжлийн чиглэлээр төрөлжүүлж үр дүнтэй зохион байгуулах.
4. Зардлын гүйцэтгэлийг төсөвт тусгаж баталсан хэмжээнд зарцуулж байх. Зайлшгүй шаардлагаар төсвөөс хэтэрсэн зардал гаргах тохиолдолд үндэслэлийг тодорхой гаргаж Хянан шалгах комист урьдчилан танилцуулж хянуулсны дараа гаргаж байх.
5. "ДБЭХС" ТӨХК-ийн бүх гишүүдийн тайлант сонгуулийн зардалд 12 сая төгрөг төсөвлөж хэтэрхий өндөр үр ашиггүй зардал баталсан. Үүнд: Видео тайланд 2 сая, амны хаалт 1,9 сая, Хөдөлмөрийн тухай хуулийн /шинэчилсэн найруулга/ 2,9 сая төгрөг, фоло подволк 140.0 мянган төгрөг, мандат 220.0 мянган төгрөг, бусад зардал гэх мэт нийт 8,2 сая төгрөг

зарцуулсан. Ном, маск, хамтын гэрээний багцыг хурал тарсны дараа гишүүдэд тараахаар шийдвэрлэсэн боловч 2022.03.30-нд тараагдсан байна. Маскны нэг бүрийн үнэ 3500 төгрөг шаардлагагүй болсон үед үр ашиггүй худалдан авалт хийсэн байна.

6. Цаг бүртгэлийг үнэн зөвөөр гаргаж, хяналт тавьж ажиллах. ҮЭХ-ны даргын 4, 11, 12-р саруудад албан томилолтоор явсан хоногуудыг Компанийн ажлын цагийн тооцоонд тусгаагүй. Албан бичиг ирээгүй тохиолдол албан томилолтоор явахгүй, төсөвлөсөн томилолтын зардлыг хэтрүүлэхгүй байх.
7. Компанийн дэргэдэх саам сувилалын сахиулын цалинг тэргүүлэгчдийн 2022 оны 2-р сарын 11-ний өдрийн №6 тоот тогтоолоор 384,000.00 төгрөгөөс 672,000.00 төгрөг хүртэл нэмэгдүүлсэн. Үүнийг 75%-иар хэт өндрөөр нэмэгдүүлсэн гэж үзэж байна. Үндэслэлгүйгээр хэт өндрөөр цалин нэмэхгүй байхыг тэргүүлэгчид анхаарах. Саам сувилал ажиллуулах нэрээр сахиул ажиллуулах, ногоо тарих, саам сувиллын тохижилт зэргээр жилд 11,2 сая төгрөг зарцуулж байгаа нь гишүүдийн татварыг үргүй зарцуулж байна. 2022 онд ногооны орлого 1800,000.00 төгрөг орно гэж төсөвлөсөн боловч 552,000.00 төгрөгийн орлого олсон байна. Цаашид саам сувиллалын сахиулын орон тоог компанийн удирдлагатай хэлэлцэж шийдвэрлэх.
8. Тэргүүлэгчид болон ХШК-ын урамшуулалыг улирал бүр олгох. Зарлагын баримтанд гарын үсэг зурж аваагүй ажилчдын урамшууллыг олгох.
9. Үйлдвэрчний эвлэлийн хорооны ажиллах журмыг сайжруулж батлах шаардлагатай. Хамтын гэрээний заалттай давхардсан заалтыг өөрчлөх.
10. Хөлсөөр ажиллах гэрээ байгуулж хуулийн дагуу татвар шимтгэл суутгаж цалин хөлс олгох.
11. Санхүүгийн болон үйл ажиллагааны бусад баримт бичгийг улирал бүр шалгуулахад бэлтгэн дараа улирлын эхний сарын 20-ны дотор Хянан шалгах комисст хүлээлгэн өгөх.
12. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгаж, QR кодоор баталгаажсан анхан баримтгүй 8,452,000.00 төгрөгийн төлбөрийг буцаан төлж барагдуулан 2023.04.30-ны дотор ХШК-т бичгээр тайлбар ирүүлэх.

ТАЙЛАН ГАРГАСАН:

ХШК-ИЙН ДАРГА

ГИШҮҮД

Н.АЗЖАРГАЛ

С.БААТАРЦОГТ

Т.БАТБАЯР

ТАНИЛЦСАН:

ҮЭХ-НЫ ДАРГА

Д.ГҮНСМАА